



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.05.20 № 22

Асуулга тавих тухай

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллыг нэгдүгээрт, гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулах, хоёрдугаарт, гэр хорооллын дундын бүсүүдэд хэсэгчилсэн дэд бүтцийг холбох, гуравдугаарт, алслагдсан бүсүүдэд инженерийн дэд бүтэц холбох гэсэн гурван чиглэлээр хөгжүүлэхээр зорьж байгаа билээ.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний 5.1.1-д Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд тусгагдсан буюу нэгдүгээр чиглэлийн хүрээнд хийгдэх ажлуудыг төлөвлөсөн байна. Гэсэн хэдий ч гэр хорооллын дундын бүсүүд болон алслагдсан бүсүүдэд дэд бүтэц холбох ажлууд хангалттай тусгагдаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээний тайланг хэлэлцэх явцад Улаанбаатар хотын гэр хорооллын дундын болон алслагдсан бүсүүдэд инженерийн шугам, дэд бүтэц холбох ажлууд цар тахлын эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан зогсонги байдалд ороод байгааг анхаарч, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон.

2020 оноос хойш гэр хорооллын дундын болон алслагдсан бүсүүдэд инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц барих төслүүдэд улсын төсвөөс санхүүжилт суулгаагүйн дээр, өмнө нь хэрэгжиж байсан төслүүдийн явц удаашран шүүхэд маргаан үүсэж, гацсаны улмаас гэр хорооллын оршин суугчдын дунд ихээхэн хүлээлт үүсгээд байна. Мөн гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдийн хэрэгжилт 30%-д ч хүрээгүй байгаа.

Эдгээрээс харахад Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгох чиглэлээр тусгасан ажлууд тавьсан

2022000046

зорилтдоо хүрэхэд хүндрэл учирч болзошгүй. Тиймээс Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж, санхүүжилтийн механизмийг үр ашигтайгаар зохион байгуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын зээл тусламжийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. 2020 оноос хойш зогсонги байдалд ороод буй гэр хорооллын дундын бүсүүдэд хэсэгчилсэн дэд бүтцийг холбох болон алслагдсан бүсүүдэд инженерийн дэд бүтэц бий болгох төслүүдийг Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах талаар болон эдгээр төслүүдийн санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын зээл тусламжаар шийдэх боломжийн талаар;

2. Гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах ажлын хүрээнд удаашралтай байгаа төслүүдийн гүйцэтгэлийг сайжруулах чиглэлд төлөвлөсөн арга хэмжээнүүдийн талаар;

3. Гэр хорооллын орчны болон хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн ажлууд, тэдгээрийн санхүүжилтийг хэрхэн шийдсэн талаар;


4. 2013 оноос хойш гүйцэтгэл нь удааширсан гэр хорооллын дахин төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлууд, тэдгээрийг түргэвчлэх чиглэлд авч буй арга хэмжээний талаар. Тухайлбал, 2013 онд эхлүүлсэн Чингэлтэй дүүргийн 14, 15-р хорооны 72-р сургуулийн орчим, 2014 онд эхлүүлсэн 9, 10, 11 дүгээр хороо Дэнжийн мянга орчим А хэсэгчилсэн талбай орчмын төслүүд одоо хүртэл ашиглалтад ороогүй байна. Эдгээр ажлуудыг хурдавчилж, төслийг үр дүнтэй гүйцэтгэж дуусгах талаар Барилга хот байгуулалтын яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

5. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Чингэлтэй дүүрэгт төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах шаардлагатай 4 хэсэгчилсэн талбай байна. Тухайлбал 2014 он А/828 захирамжаар ЧД-ийн 9, 10-р хороо, Дэнжийн мянга орчмын Б хэсэгчилсэн талбай, 2013 он А/1041 захирамжаар ЧД-ийн 9, 10-р хороо, Дэнжийн мянга орчмын В хэсэгчилсэн талбай, 2014 он А/831 захирамжаар Чингэлтэй дүүргийн 7, 8 дугаар хороо, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, МҮОНРТ орчимд, 2014 он А/962 захирамжаар Чингэлтэй дүүргийн 7, 8 дугаар хороо МҮОНРТ орчмын төслүүдэд хэрэгжүүлэгч байгууллагатай маргаан үүсч, үйл ажиллагаа нь гацсан байна. Эдгээрийг эрчимжүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй бусад арга хэмжээний талаар зэрэг болно

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



М.ОЮУНЧИМЭГ

2022000046